

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МОНГОЛ ЁС ЗАНШЛЫН ОНЦЛОГООС

Ж.Санжид

ШУА-ийн Ботаникийн хүрээлэн

Түлхүүр үг: газар усны эзэн, нүглийн золиос, цогцолбороор хамгаалах, савны хэмжээ, таван хошуу мал, даяаршлын нөхцөл.

Унаган байгаль хүрээлэн байгаа орчноо харьцангуй онгон байдлаар өнөө үе хүртэл хадгалж чадсан ард түмэн бол монголчууд юм. Энэ гайхамшигт ололт нь манай өвөг дээдэс байгалиа хамгаалж ирсэн өвөрмөц ёс заншил, зан үйлийг нарийн чанд гүйцэтгэж, дараа үеийнхэндээ өвлүүлж чадсаны үр дүн болой.

Монгол орны нэг онцлог бол байгаль нь маш эмзэг. Ийм учраас зайлшгүй хамгаалах, ариглаж эдлэх шаардлагатай бөгөөд эзэн нь болж хандах нь чухал байдаг. Сийрэг тачир ургамлан нөмрөг, “хутганы ир” шиг нимгэн хөрсний давхарга, хаа л бол хаана өртөхөд бэлэн ан амьтад, ус ундарга арвин ч тэр орчиндоо л ганц нэгхэн худаг ус, сэмжин үүл гарвал маргааш нь шуургаа тавиулж чаддаг хөх тэнгэр. Энэ бол ихээс их эмзэг зүйлс, аль нэг нь л амь тасарвал амь амьдрал алдахад бэлэн зэхээстэй байдаг. Иймээс бидний өвөг дээдэс байгальтайгаа яг л шилэн бөмбөг барьсан хүн шиг эрхэмлэн харьцаж ирсэн. Энэ эмзэг бүгдийг хамгаалахын тулд далай мэт арвин ёс заншлыг бий болгож тэнгэр мэт дээдэлж байсан.

О.Амархүү¹ доктор бүтээлд хүрээлэн байгаа орчны талаарх уламжлалт Монгол мэдлэгийг үндсэн агуулга, зарчмаар нь

1. Энэрэл хүндэтгэлийн уламжлал
2. Сургаал номлолын уламжлал
3. Сүсэг бишрэлийн уламжлал
4. Ажиглан танин мэдэхүйн уламжлал
5. Хорио цээрийн уламжлал хэмээн ангилсан.

Ж.Санжид² хамгаалагдахууныг гал, тэнгэр, уул, ус, амьтан, ургамал гэсэн хэсгүүдэд ангилаад ёс заншил, зан үйлээ үйлдэх хэлбэрээр нь

1-рт, билэгдэл /Бөртэ чоно, ухаа марлыг монголчуудын дээд өвөг гэж үздэг, ногоон өнгөөр арвижин дэлгэрэхийг билэгдэнэ/,

2-рт, хорио цээр /голын усанд улай, цагаа оруулдаггүй, цагаан буга, тарвагыг агнадаггүй/,

3-рт, үйлдэх зан үйл /аргалын дөрвөлжийг дүүрэн хонуулдаг, газар хөндөхдөө оронгын эвэр, гахайн соёо, очироор эхэлж хүрдэг/,

4-рт, өгүүлэн үйлдэх /овоонд чулуу өргөхдөө овооны өндрийг таньд өргөө, олзны ихийг мандиа хайрла хоржийлоо гэж хэлдэг/,

5-рт, хуульчлагдсан зан үйл /тарвага утаад авалгүй орхисон хүнээс шүдлэн морь ав/ гэж Арван цагаан буянт номын цагаан түүхэнд өгүүлжээ.

6-рт, домгоос үйдсэн зан үйл /аалз нь муу хүний сүнс учраас сайн төрөлд нь очуулах гэж егүүтгэдэг, шөнө хүүхдийг усанд явуулбал сар хүүхдийг нь аваад явчихна/ гэж зургаан бүлэг болгон хуваажээ.

Байгаль хамгаалах Монгол ёс заншил дараах онцлогуудтай билээ.

1. Байгальтайгаа зөв харьцаж сурсан Монгол түмний хамгийн чухал гэж хэлж болох онцлог бол уул усаа эзэнтэй болгож байсан үйл юм. Түүхийн урт хугацааны туршид уул усны эзэн нь гурван хэлбэртэй байсан.

а/ Өнө эртний цагт байгалийн сүр хүчний өмнө айн ширвээтэж тухайн уул усныхаа эздийг өөрсдийн мэдэх хүчирхэг болон сүртэй догшин амьтадаар төсөөлөн төлөөлүүлж биширч байв.

Үүний бат³ алгаа нь доод чулуун зэвсгийн үеийн уран зургийн үзэсгэлэн буюу бишрэлийн “сүм” болсон Хойд Цэнхэрийн агуйд байгаа сүг зурган дотор ирвэс,

³ Цэвээндорж Д. Монголын эртний урлагын түүх. УБ., 1999.

барс, хирс, тэмээн хяруул, гацуур³ /энэ нь зандан модны зураг байж болзошгүй/ -ын зургуудыг дүрсэлсэн буй. Тухайн цагт Монгол нутагт дээр дурьдсан амьтад бүхий саваннад эдгээр амьтадтай хамт хүн төрөлхтний өвөг (монголчууд) хамтдаа амьдраад тэдний сүр хүчинд дарагдан биширч хүндэтгэж байжээ. Энд нэн ховор атлаа сүрлэг догшин амьтад нь бар, тэмээн хяруул, зандан мод зэрэг байсан болотой. Эртний тэр цагт эдгээр амьтдаа тэр сүмдээ зурж, түүндээ биширч уул усныхаа эзэд болгон ойлгож байсан. Энэ нь монгол түмний тотемийн шүтлэгийн нэг хэлбэр юм.

б/ Олон овог омгууд өөрсдийгөө аливаа амьтдаас гаралтай, зарим нь бүр мод бутнаас гаралтай гэж үзнэ. Овгийн шүтээн болсон амьтдаа ихэд биширч хүндэтгэн шүтдэг ёсон аль ч оронд байдаг. Үүнтэй төсөөтэйгээр Монголын олон овог шүтээнээ хүндэтгэн чононоос үүдэлтэйнүүд нь өөрсдийгөө чоносууд, булганаас үүсэлтэйнүүд нь булгачууд (булганчууд, *Vulgary*-ууд), хэрээнээс үүссэнүүд нь хэрэйд гэх мэт нэрлэжээ. Энэ мэтээр нохой, хун, баавгай гэх мэтээс үүссэн гэдэг. Өнөөгийн Монголд иймэрхүү амьтдаар овгоо нэрлэсэн нь 50 гаруй байгаа. Бас харгана, нарс, жигд мэт ургамлаар овгоо нэрлэгсэд 10 гаруй байдаг.⁴ Ингэж овгоо амьтан ургамлаар нэрлэгсэд тухайн овгийн онго буюу шүтээнийг мод болон бусад зүйлсээр хийж, хадгалан шүтэхээс гадна үүслийн онго болсон амьтдаа /ургамлаа/ халдах нь битгий хэл үргээж цочоодоггүй юм.

в/ Бөө хүнийг наснаас халихаар нь цогцсыг нь аль нэг ууланд оршуулаад сүнсийг нь тэр уул усны эзэн болгож оршоодог. Энд бөөгийн цогцсыг оршуулсан гэсэн тэмдэг болгож дээр нь чулуу овоолдог. Эртний эзэнтэй уулын овоо ингэж үүссэн. Энэ эзэн нь буюу бөөгийн сүнс нь үе залгасан бөөтэйгээ харьцаж байдаг. Нас нөхцсөн бөөгийн сүнсийг буюу эзнийх нь онгод гэж нэрлэнэ. Иймээс "Монгол бөө нар (ер нь монголчууд Ж.С.) газар усыг эзэдтэй гэж шүтдэгтээ бус харин газар усны эздийг нь тахин шүтдэг учраас монголчууд газар усаа эрхэмлэж дээдэлдэг эрхэм ёс бүрэлдэн тогтсон."⁵

Монгол түмний дунд юм бүхэн эзэнтэй гэдэг ойлголт их түгээмэл байдаг. Аливаа юмны эзэн нь хоёр янз байна. Нэг нь монгол оронд оршиж байгаа бүх юмс (өвс ногоо, хад чулуу, гол ус гэх мэт зүйлс) бүгд уул усны эзний газар нутаг дээр оршин байдаг. Иймд эдгээр юмс болон юмсын үйлээр үүссэн үзэгдэл бүгд эзний л газар дээр байгаа учраас газар усны эзний харьяалалд оршино. Нөгөө эзэн нь юм бүгд өөрийн сүнсстэй. Тэр сүнс нь тухайн юмныхаа эзэн нь болж байдаг.

Алтайн урианхай Эричгэний Зараа бөөгийн Газар усны эздийн дуудлагад:

Эм болсон өвсний эзэн

Эрдэнэ болсон чулууны эзэн

Алтан болсон асганы эзэн

Мөнгөн болсон хадны эзэн

Торгон болсон лусын эзэн

Бурхирч урссан булгийн эзэн

Сархирч урссан дэвийн усны эзэн

Гарын хуруун болсон садаргын эзэн

Сарвалаж өгсөн хадны эзэн

Арвалаж өгсөн савдагийн эзэн

Тэр бүгд минь өршөө⁶ (В.Ринчен 1975, 111, 49-50-ийг Монголын соёлын түүх I боть 1999-өөр дамжуулан авлаа) гэхчилэн урьж залж дууддаг. Эл дуудлагын нэгэн нэвтэрхий санаа бол эзэнгүй "хоосон" юм гэж ертөнцөд үгүй гэсэн санаа юм.

Газар усыг эзэнтэй болгох нь бүр удганы бишрэлтэй холбоотой. Удганыг наснаас нөхцөхөөр нь билэг чанартай учраас нам газар оршуулаад дээр нь мод тарьж орхидог байв. Ингэж модон зэвсэгтэй байх үеэс л уул усны эзэн нь удганы

⁴ Сэржээ Ж. Монгол овгийн нэрийн учир. УБ., 1999.

⁵ Пүрэв О. Монгол бөөгийн шашин. УБ., 1999.

⁶ Монголын соёлын түүх. I боть. УБ., 1999.

сүнстэй болсон. Сүүлд бөө мөргөлийн үеэс арга чанартай учраас цогцсыг нь өндөр газар оршуулан мод тарихын оронд чулуун овоо босгодог болсон.

Шарын шажин дэлгэрэхийн хамт уул усны эздийг савдаг газар, лусын гэсэн үгээр төвдчилөн хоршоо үг болгон нэрлэдэг болсон.

Энэ эзний таалалд нийцэхгүй үйлдлийг хийвэл лус савдаг хилэгнэж хорлодог.

2. Монгол орны экологи харьцангуй бага хөндөгдөж өнөө үед ирсэн нь бичигдээгүй боловч хууль мэт байсан зан заншлаа ягштал хэрэгжүүлж, хүмүүс бие биедээ өндөр зарчимч шаардлага тавьж түүнийгээ хүн бүр ёсоор нь гүйцэтгэдэг байсантай ихээхэн холбоотой юм. Ер нь Монголд хүний хүүхэд гэж байгаагүй. Бүх хүн буруу хэрэг хийсэн хүүхдийг зэмлэдэг, загнадаг, зоддог, шийтгэдэг байлаа. Үүний улмаас хүүхэд багаасаа том хүнээс эмээдэг буюу том хүн байхгүй газар гэж байхгүй учраас буруу хэрэг зориуд хийчих газар олддоггүй байв. Бүх хүн "нүглийн золиос" болохоос айдаг. Хэн нэгэн болчимгүй этгээдийн үйлдсэн нүглийн золиосыг бүх нийтээрээ, отог, сум хошуугаараа эдэлдэг тул нүгэл үйлдэгч буюу байгальтайгаа солгой харьцагч этгээдэд хатуу өндөр шаардлага тавьж тухайн солгой үйлдлийг зогсоож чаддаг байсан. Гэтэл энэ зарчим алдагдсанаас нүгэл их үйлдэж түүний золиосыг даян олноороо их үүрэх боллоо. Энд нэгэн тохиолдлыг дурдахад: 1970-аад оны эхээр Өмнөговь аймгийн Ноён суманд намын дарга, эвлэлийн дарга, жолооч гурав могойн чуулган болж байхтай тааралдаж бензин асгаж шатаажээ. Үүний улмаас дээрх гурван хүн зовж үхээд зогссонгүй, тэр нутаг хорь гаруй жил хур бороо оролгүй гандаж хүн, мал нь ихэд зовсон гэж Төв аймгийн аргалант сумын Үйлдвэрчний эвлэлийн дарга Ж.Пүрэв ярьсан билээ. Монгол хүн байгальтайгаа нягт харьцаатай, байгалийнхаа эрхшээлд байдаг. Ийм учраас байгалиа аргадаж, байгалиасаа хэрэгтэй юмаа гуйж авдаг, байгалиа хамгаалах технологую мэддэг. хамгаалах чадвар бүрэн эзэмшсэн, цээр болгоныг ёсчлон гүйцэтгэдэг байв.

3. Байгаль орчноо хамгаалах ажилдаа цогцолбороор ханддаг. Өөрөөр хэлбэл экосистемийн түвшинд нь, шим мандлын түвшинд нь, бүр цаашилбал эх болсон зургаан зүйлийн хамаг амьтны түвшинд шүтэн биширч хамгаалж иржээ. Уул усны тахилгын үед тэр уулын орчныг бүхэлд нь хамгаалаад амьтан ургамлыг нь, тэр ч бүү хэл тэнд амьдарч байгаа хүмүүсийнх нь сэтгэл санааг нь хүртэл ариусгаж өгдөг.

Голын эхний модыг огтолдоггүй байх нь чухал. Гэхдээ голын эхний модны ургах нөхцөлийг бүрдүүлж байгаа тухайн модноос дээш орших хөрс шороо, хад чулууг нь ч хөнддөггүй. Хэрэв хад чулууг нь хөндвөл шим тэжээлийнх нь болон усных нь түвшин доошилдог. Иймээс тухайн орчны модны ургах орчин доройтно. Улмаар мод тэнд ургахаа болино. Мөн тэр модыг нь авбал түүнээс доош урсаж буй усных нь түвшин доошилж гол мөрөн, булаг шанд хатаж ширгэнэ. Үүнээс болж тэр орчимд нь байгаа ан амьтад, хорхой шавьж бүгд үхэж үрэгдэн, үргэн дайжих болно. Ийм учраас монголчууд байгальтайгаа харьцахдаа дараагийнх нь сөрөг нөлөө, өөрт учрах нүгэл, хойт насныхаа цөвийг эхэлж тооцдог. Хэрэв зайлшгүй шаардлага гарвал уул усаа, тухайн орчноо аргадан зөвшөөрөл авч байж гар хүрдэг байв. Монголчууд байгаль хамгаалах ёс заншил, зан үйл нь экосистемийн, популяци, бодгалийн түвшинд хийгддэг. Бодгалийн түвшин нь захын ганц модыг, ганц нэгээрээ төөрч тэнэж яваа, амиа хамгаалах чадваргүй болсон амьтад шинээр урган төлжиж эхэлж, тархацаа тэлж байгаа мод бут, гоц ашигтай эмийн ургамлуудыг хамгаалах ажил дээр илэрдэг. Популяцийн түвшинд хийгддэг ажил нь байгаль хамгаалах зан заншлын ихэнхийг эзэлдэг. Цөөн модтой төгөлийг олон модтой болгон Зуун мод, Баян тоорой, Мянган тооройн булаг гэж билэгдэн хамгаална.

4. Байгаль хамгаалахтай холбоотой ойлголт, үйлдлүүдийг хүмүүсийн сэтгэн бодох, мэдлэг чадварын түвшинд нь тулгуурлан үйлдүүлдэг, заншуулдаг байлаа.

Эгэл буюу ном судраас ихэд хөндий, ухаарч ойлгож чадахгүй хүмүүсийн сэтгэл зүйд нь тохируулан буян нүгэл, лус савдаг гэх мэт нүдэнд үл үзэгдэх, үл ойлгогдох ухагдахууныг ашиглан тайлагдашгүй, ухаарч чадашгүй мэдэх боломжгүй шүтээнүүдийг бий болгож байв. Үнэхээр ухааж ойлгож чадахгүй усан нүдтэй, цусан зүрхтэй, тосон тархитай хүмүүст лус савдаг, газрын эзэд, онго онгод сүнсний асуудал мэдэгдэхгүй зүйл л дээ. Энэ ёс заншил зан үйлдлүүдийг зөрчвөөс энэ насны нүгэл, лус савдагийн хорлол болно гэж үнэнийг өгүүлдэг байв. Гэтэл ухаарч чадах ном эрдэмтэй, ухаан сайтай, буян хишгээ хуурайлан дуудаж чаддаг ихсүүдийг хутагт хувилгаад болгон залж, ном судар сан тахилга зохиолгож ханддаг байсан.

Мэдлэгийн түвшнээр дорой доод төрөлтөнгүүдээр нүгэл үйлдүүлэхгүй байж, өөрсдөө, үйлдэгч нараа, хүн зон нараа нүглийн золиос болгохгүй байхыг эрхэмлэн дээд болгодог байв.

Хүүхдийг хэл, хөлд орох цагаас нь байгаль орчны тухай мэдлэг олгож, тусад орох цагаас нь орчин ба байгальтай нь зөв харьцуулж эхэлдэг. Аргал оруулах, хол ойр явах, морь харах, уул чулуунд цацал чулуу өргөх зэрэг ёсыг байгальтайгаа харьцах алхам бүрээ нүгэл буяны дэнсэнд тавиулж, дараа үеийнхэндээ зааж зааварчилж, загвардан дагуулж, дуурайлган хийлгэж, сурган хүмүүжүүлж, чадвар дадал болгодог байв. Нутаглаж байгаа газар усаа биднийг ивээн тэтгэж, тэжээж байгаа гэдгийг дэс дараатай, учир шалтгаан, дотоод зүй тогтлыг учирлан ухааруулдаг байлаа. Судалгаанаас үзэхэд монголчуудын байгаль хамгаалах зан заншлын 40 гаруй хувийг 3-12 насанд нь эзэмшүүлбэл үр дүнтэй болдог аж. Үүнээс гадна нас биед хүрч айл гэр болж, гал голомтоо бадраах үед тусгайлсан зан үйл эзэмшүүлдэг байв.⁷

5. Монгол орны байгаль онгон дагшнаараа үлдэхэд нөлөөлсөн голлох хүчин зүйлийн нэг нь сонгодог нүүдлийн мал аж ахуй юм. Төв Азийн уудам дэлгэр атлаа гандуу гундуу нутаг дэвсгэрт таван хошуу мал адуулан эдэлснээр урт хөлийн бод мал /адуу, үхэр, тэмээ/ алсын бэлчээрт нь, богино хөлийн бог мал ойрын бэлчээрийг нь идээшлэж бэлчээрлэснээр бог ба бод малын бэлчээр давхцаж, бэлчээр талхлагддаггүй байсан.

Нүүдлийн амьдралаас суурин соёл иргэншилд шилжихийн хирээр түүний зааг дээр байгальд харьцаж халдах түүхт уламжлал алдагдаж, байгалиа хэмээх хүний уян зөөлөн сэтгэл хатуу ширүүн зан авираар солигдох болж буйг анхаарахгүй өнгөрч болохгүй.⁸

Байгаль хамгаалах асуудал бүхэлдээ уламжлал шинэчлэл хоёрын шүтэлцээ, өнгөрсөн одоо ирээдүй гурвын нэгдэл болой.⁹

Байгальтайгаа зөв харьцана гэдэг бол өнгөрсөн, одоо, ирээдүйн хүн төрөлхтөний өмнө хүлээсэн нэн их хариуцлагат соёл юм.

“Байгаль хүрээлэн байгаа орчноо хайрлаж хамгаалж, нөөц даацынх нь хэмжээнд тохируулан хэрэглэх, экологийн соёл боловсрол, хүмүүжил олгоход онолын мэдлгээс гадна бидний өвөг дээдсийн байгаль орчноо хайрлан хамгаалж ирсэн өв уламжлалаас суралцах нь зайлшгүй чухал юм”.¹⁰

Хүн төрөлхтөн байгалийн сүр хүчинд дарагдан зөвхөн түүний өгөөж буянаар амь зогоон амьдарч байсан. Харин “төмөр техник” бий болсноор эх болсон байгаль руугаа гар далайн харьцдаг, баялагийг нь булаан авдаг болсон сүүлийн үед дэлхий даяараа байгальтайгаа зохицон амьдрах, аргадан аж төрөх чиг хандлагыг барьж байна. Гэтэл энэ үзэл баримтлалыг монгол түмэн эртнээс нааш

⁷ Санжид Ж. Байгаль хамгаалах зан үйл ба экологийн тасралтгүй боловсрол // Байгаль хамгаалах монгол уламжлал, УБ., 1995

⁸ Амархүү О. Байгаль орчныг хамгаалах монгол заншил хууль цааз, УБ., 2000.

⁹ Санчир Ч. Дуламсүрэн С. Монголчуудын байгаль хамгаалах уламжлал // Монгол орны байгаль орчны төлөв байдал, УБ., 2002.

¹⁰ Тунгалаггэрэл Т. Монголчуудын байгаль хамгаалах ёс заншлын өнөөгийн ач холбогдол // МУИС-ын эрдэм шинжилгээний бүтээл, 2002, №17/13/

барьж хэрэгжүүлж иржээ. Ийм учраас байгалиа хамгаалж ирсэн монгол зан заншил, зөвхөн монгол орны байгалийг хамгаалахад төдийгүй экологийн хямралтай байгаа даяны хүрээнд хэрэглэх боломжтой юм.

Монгол орны экосистем маш эмзэг. Ийм учраас монголчууд байгалиа хамгаалах олон зүйл ёс заншлыг бий болгосон. Энэ ёс заншил нь өөрийн орны экологийн төрх байдал, монгол сэтгэл зүйн өвөрмөц байдалтай таарсан онцлогтой.

Монгол орны уул ус нь өнө эртнээс үүдэлтэй эзэдтэй байдаг бөгөөд энэ эздийг тахиж шүтэн, тэдний орчныг нь ариун онгон байлгах эрхэм ёсыг бий болгон байгалиа хүндлэн шүтдэг зан заншил бий болгоод түүнийгээ чандлан мөрддөг байв.

Байгалиа хамгаалах ажил нь цогцолбор байдаг бөгөөд өөрөөр хэлбэл ганц нэгхэн мод бут, амьтдыг хамгаалдаггүй, уултай устай нь, ургамал амьтантай нь бодгаль, популяци, экосистемийн түвшинд нь хамгаалдаг.

Байгаль хамгаалахтай холбоотой ойлголт зан үйлийг хүмүүсийн оюуны савных нь түвшинд тулгуурлан үйлдүүлдэг, заншуулдаг байв.

Монгол орны байгаль онгон дагшнаараа үлдэхэд нөлөөлсөн нэг чухал хүчин зүйл нь сонгодог нүүдлийн мал аж ахуй юм.

Байгалиа хамгаалж ирсэн Монгол зан заншил нь дэлхий дахинаараа нэг дээвэртэй болсон даяаршлын өнөөгийн нөхцөлд зөвхөн Монгол орын төдийгүй даян дэлхийн ач холбогдолтой.

Резюме

Ж.Санжид

Экосистема Монголии очень хрупкая, поэтому наш народ сотворили многочисленные обряды и обычаи, подходящие к психологии человека и экологической среды Монголии. Монголы комплексно относились по вопросу охраны природы.

Горы, реки и озёра нашей страны имели и имеют своего хозяина /лус и савдаг/ с давних пор и до сегодняшнего дня. Это имело большое значение для сохранения природы.

Кочевое и классическое скотоводство положительно влияло на рациональное использование пастбищных ресурсов и природных условий. Природоохранная проблема остропоставляющие наши дни традиционные обычаи охраны природы нашего народа имеют многосторонние значения не только для сохранения природных богатств Монголии, но и для глобального масштаба.